



**МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2024 оны 6 сарын 10 өдөр

Дугаар 8/МТ

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалт, 9.8 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын 6.1, 6.3, 6.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчдын 2024 оны хагас жилийн ажлын гүйцэтгэл, мэргэшлийн түвшинг үнэлэх үнэлгээний багийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний багийн дарга:

С.Мяндасмаа

Төрийн захиргааны удирдлагын газрын
Хуулийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ч.Сугармаа

Авто замын бодлого зохицуулалтын газрын
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

Х.Итгэлт

Төмөр зам, далайн тээврийн бодлого
зохицуулалтын газрын даргын албан
үүргийг түр орлон гүйцэтгэгч

Б.Бат-Өлзий

Салбарын хяналтын газрын дарга

Т.Мягмарсүрэн

Автотээврийн бодлого зохицуулалтын
газрын Тээвэр зохион байгуулалтын
хэлтсийн дарга

Ц.Мядагмаа

Бодлого, төлөвлөлтийн газрын Судалгаа,
стандарт, статистикийн хэлтсийн дарга

Л.Баянзул

Авто замын бодлого зохицуулалтын газрын
Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар
хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр хариуцсан
ахлах шинжээч

Ц.Нэргүйбаатар

Автотээврийн бодлого зохицуулалтын
газрын Автотээврийн салбарын бодлого
хариуцсан ахлах шинжээч

Э.Солонго	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
Б.Өлзийжаргал	Бодлого, төлөвлөлтийн газрын Салбарын дэд бүтцийн бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн
Г.Даваадолгор	Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын Төмөр замын зорчигч тээвэр хариуцсан мэргэжилтэн
Д.Хишигбаатар	Салбарын хяналтын газрын Эрсдэлийн удирдлага, улсын байцаагчийн эрх олгох, цуцлах асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн
У.Мөнхцэцэг	Иргэний нисэхийн бодлого зохицуулалтын газрын Нисэх буудлын бодлого, төлөвлөлт, дотоод үйл ажиллагаа хариуцсан яамны ахлах зохион байгуулагч
Нарийн бичгийн дарга: Б.Цэнд	Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах шинжээч

2.Журмын 6.5-д заасны дагуу үнэлгээний ангиллыг эрэмбэлэн нэгдсэн дүнг танилцуулж, улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллыг холбогдох журмын дагуу тооцон олгуулах санал ирүүлэхийг үнэлгээний баг (А.Мөнхбат)-т даалгасугай.

3.Үнэлгээний багийн гишүүд журмын 7.2-д заасны дагуу нууцын баталгаа гаргаж ажиллахыг үүрэг болгосугай.

4.“Маш сайн” үнэлгээний ангилалд хамрагдсан албан хаагчид олгох мөнгөн урамшууллын хэмжээг албан хаагчийн албан тушаалын үндсэн цалингийн 80 хувиар, “Хэвийн” үнэлгээний ангилалд хамрагдсан албан хаагчид олгох мөнгөн урамшууллын хэмжээг “Маш сайн” ангилалд хамрагдсан төрийн албан хаагчид олгох мөнгөн урамшууллын 50 хувиас хэтрэхгүй хувиар тус тус тогтоосугай.

5.Албан хаагчдын үнэлгээний дүнг 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор байгууллагын цахим хуудсаар болон дотоод мэдээллийн сүлжээгээр нээлттэй мэдээлэхийг Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга (Б.Цэнд)-д даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

С.БАТБОЛД

